

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2022 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БНА-2023/01-НА-СТА

Цахим хуудас:

www.audit.mn

Баянхонгор хот

2023 оны 04 дүгээр сарын 25

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584

Аудитын менежер: А.Цээням

Утас: 70442424

Ахлах аудитор: М.Алтантуяа

Утас: 99061861

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393

Аудитор: Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn

Цахим хаяг: Usukhbayari@audit.gov.mn

Цахим хаяг: bunchisurenn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<p>Тайланг хянасан</p> <p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат</p> <p>Аудитын менежер А.Цээням</p> <p>Тайланг бэлтгэсэн</p> <p>Ахлах аудитор М.Алтантуяа</p> <p>Аудитор Ж.Өсөхбаяр Н.Бүнчинсүрэн</p> <p>2023 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр</p> <p>Уг тайланг УАГ-ын Цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn</p> <p>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар Аймгийн ЗДТГ-ын байр, Баянхонгор сум, Баянхонгор аймаг-64000 Монгол Улс</p>	<p style="text-align: center;">АГУУЛГА</p> <p>Аудитын зорилт, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ 3</p> <p>Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх 3</p> <p>Аудитын зорилт 3</p> <p>Аудитын хамарсан хүрээ 3</p> <p>Аудитын арга зүй 4</p> <p>Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт 4</p> <p>Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн 4</p> <p>Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам 4</p> <p>Товчилсон үгийн тайлбар 5</p> <p style="text-align: center;">ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 5</p> <p>Бүлэг 1. САНГИЙН ЯАМ АЙМАГТ ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГЭЭС ӨМНӨХ ОНУУДЫН ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛСЭН ЗЭЭЛИЙН ТӨЛБӨРТ 548.8 САЯ ТӨГРӨГИЙГ СУУТГАН ТООЦОНООС 8 СУМАНД ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙГ НИЙТ 134.4 САЯ ТӨГРӨГӨӨР ДУТУУ ОЛГОСОН БАЙНА 6</p> <p>1.2 Татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэл .8</p> <p>Бүлэг 2 Аймгийн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2022 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 22.2.4 дэх хэсэг, 24.5, 24.6 дахь заалтын дагуу батлуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан эсэх. 15</p> <p>Бүлэг 3 Аймгийн төсвийн Ерөнхийлөн Захирагчийн Эрхлэх Асуудлын хүрээний төсвийн орлого, зарлагыг зүй зохистой, үр ашигтай байдлаар Төсвийн тухай хуулийн 54.5-т заасан бүрэлдэхүүнээр гарган, хэрэгжүүлж хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтод түвшинд нийцсэн байна. 23</p> <p>Бүлэг 4. Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн түвшинд гаргасан зарим шийдвэрүүд нь хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолд нийцээгүй, зарим байгууллага албан тушаалтан хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. 25</p> <p>Бүлэг 5 Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулж, түүнд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласнаар Шилэн дансны тухай хуулийг зөрчсөн зөрчил буурсан байна. 31</p> <p>Бүлэг 7. Баянхонгор аймгийн 2022 оны төсвийн төсөлд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна. 34</p> <p>Үндэсний аудитын газарт хүргүүлэх санал 36</p> <p>АУДИТЫН ДҮГНЭЛТ 36</p> <p>АУДИТЫН ЗӨВЛӨМЖ 37</p>
---	--

**Аудит хийсэн
үндэслэл, бүрэн
эрх**

**АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ
МЭДЭГДЭЛ**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5¹-д заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай” 2022 оны А75 дугаар тушаал, газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023.01.13-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” тушаалыг үндэслэн Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын зорилт

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг шалгаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд

- Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх,
- Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 22.2.4 дэх хэсэг, 24.5, 24.6 дахь заалтын дагуу батлуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан эсэх.
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн орлого, зарлагыг зүй зохистой, үр ашигтай байдлаар Төсвийн тухай хуулийн 54.5 -т заасан бүрэлдэхүүнээр гарган, хэрэгжүүлж хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтод түвшинд нийцсэн эсэх.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлэн ажилласан эсэх
- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан эсэх
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан эсэх
- Баянхонгор аймгийн 2022 оны төсвийн төсөлд өгсөн зөвлөмжийн хэрэгжүүлсэн эсэхэд аудитын анхаарлаа хандуулав.

**Аудитын хамарсан
хүрээ**

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Татварын хэлтсийн аудитад хамрагдах хэсгийн татварын төлөвлөгөө, тайлан, Сангийн яамнаас Баянхонгор аймгийн 2022 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

¹8.9.4.аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, MNS 6817-4:2020 “Төрийн аудит. Санхүүгийн аудит”, 6817-6 :2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, МУЕА-ын 2021 оны А/71 тушаал “Заавар аргачлал батлах тухай” журмын аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол улсын 2022 оны төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Тусгай сангийн тухай хууль
- ТБОНӨТХ
- ТБОНӨБАҮХАТХ
- Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”
- 2022 оны А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналд тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”
- Төрийн аудитын байгууллагаас 2022-2023 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл
- Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд
- Холбогдох бусад хууль тогтоомж

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер А.Цээням үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Алтантуяа, аудитор Ж.Өсөхбаяр, Н.Бунчинсүрэн нар 2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам

Аудитын тайланг үндсэн мэдээлэл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж гэсэн агуулгаар бичиж, аудитын тайланд аудитын менежер, тэргүүлэх аудитор нараар үе шатны хяналт хийлгэж, тайланг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга нарт хүргүүлэв.

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрлэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨ	Орон нутгийн өмч
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨХЭ	Орон нутгийн өмчит хуулийн этгээд
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТБОНӨХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгө
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦХТАО	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Тайлант онд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан аймгийн төсвийн татварын орлогод аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь, сумын төсвийн татварын орлогод хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татварыг, Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрт малын тоо толгойн албан татварын орлогыг оруулан тооцох зэрэг бодлогын өөрчлөлтүүд орсон байна.

Төрийн аудитын газраас Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн төсөлд тусгагдсан төсвийн суурь орлогыг 584.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, суурь зарлагыг 697.0 сая төгрөгөөр бууруулах, төсвийн үр ашгийг 5,184.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, нийт 6,465.2 сая төгрөгийн саналыг хүргүүлсэн.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.12.01-ний өдрийн 6/24 дугаар “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” тогтоолоор аймгийн төсвийн татварын орлогыг 1,882.5 сая, татварын бус орлогыг 1,536.7 сая, хөрөнгийн орлогыг 40.0 сая, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 21,548.8 сая, орон нутгийн нэгдсэн сангаас олгох санхүүгийн дэмжлэг 10,931.8 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 508.0 сая, өмнөх оны төсвийн үлдэгдлээс 1,180.0 сая нийт эх үүсвэрийг 37,627.7 сая төгрөг, 2022 оны төсвийн жилд зарцуулах нийт зарлагыг 37,627.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/24 дугаар “Аймгийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” тогтоолоор аймгийн төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг

татварын болон татварын бус орлого 3,699.1 сая, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 17,678.0 сая, улсын төсвөөс олгох ОНХС-ийн шилжүүлэг 10,140.5 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 508.0 сая, аймгийн төсвийн өмнөх оны үлдэгдэл 3,196.0 сая төгрөг нийт эх үүсвэрийг 35,221.6 сая төгрөгөөр баталж аймгаас сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 9,156.5 сая, (Баян-Овоо сум 241.4 сая, Баянхонгор сум 713.6 сая нийт 955.0 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэх, аймгаас бусад сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 10,111.6 сая), аймгийн ОНХС-д 4,990.7 сая, замын санд 1,575.9 сая, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 1,888.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан.

Тайланд онд аймгийн татварын орлогоор 16,597.2 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс 21,757.6 сая төгрөг оруулж, төлөвлөгөө 5,160.4 сая төгрөгөөр давуулан биелсэн байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төсвийн нийт зарлага 51,608.7 сая төгрөг ба үүнээс урсгал зардалд 39,544.5 сая, хөрөнгийн зардал 11,515.4 сая төгрөг зарцуулж, эргэн төлөгдөх зээлээс 548.9 сая төгрөгийг төлсөн бөгөөд орон нутгийн төсвөөс 39,647.9 сая, ОНХС-аас 10,113.3 сая, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1,776.5 сая нийт 51,537.7 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлжээ.

Аймгийн ТЕЗ-ийн дүнгээр дээрх тайланд онд 58,993.2 сая төгрөгийн төсөв батлагдаж 51,608.7 сая зарцуулснаас урсгал зардалд 39,544.5 сая, хөрөнгийн зардалд 11,515.4 сая төгрөг зарцуулсан байна.

АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. САНГИЙН ЯАМ АЙМАГТ ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГЭЭС ӨМНӨХ ОНУУДЫН ДАМЖУУЛАН ЗЭЭЛДҮҮЛСЭН ЗЭЭЛИЙН ТӨЛБӨРТ 548.8 САЯ ТӨГРӨГИЙГ СУУТГАН ТООЦСОНООС 8 СУМАНД ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙГ НИЙТ 134.4 САЯ ТӨГРӨГӨӨР ДУТУУ ОЛГОСОН БАЙНА

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар Баянхонгор аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгээр 17,678.0 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 10,140.4 сая, нийт тусламж санхүүжилтийн орлогыг 27,818.4 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс Сангийн яаманд татварын орлогыг 10,290.0 сая, хүү, торгуулийн орлогыг 1,050.0 сая, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 20.0 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 100.0 сая нийт 11,460.0 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлснийг Сангийн яам татварын орлогыг 13,805.0 сая, татварын бус орлогыг 2,481.3 сая төгрөг, хөрөнгийн орлогыг 20.0 сая төгрөг нийт 16,306.3 сая төгрөгийг оруулахаар хянаж баталсан байна. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд оруулсан 2022.04.29-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр нийт орлогыг 129.0 сая төгрөгөөр бууруулан 16,177.3 сая төгрөгөөр баталсан.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.12.01-ний өдрийн 6/24 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 16,536.8 сая төгрөг, татварын бус орлогыг 3,284.6 сая, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 21,548.8 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох

дэмжлэг 10,931.8 сая, СХС, ОНХС-ийн бусад эх үүсвэр 1,636.4 сая, өмнөх оны төсвийн үлдэгдэл 6,443.3 сая төгрөг нийт эх үүсвэр 60,421.6 сая төгрөгөөр, 2022 онд аймгийн төсвөөс зарцуулах зарлагыг нийт 60,421.6 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2022.05.25-ны өдрийн хуралдааны 9/24 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор анхны батлагдсан төсвийг 1,428.4 сая төгрөгөөр бууруулан нийт 58,993.2 сая төгрөгөөр төсвийг баталсан байна.

Энэ нь Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2022.04.29-ны өдрийн нэмэлт өөрчлөлт, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг орон нутгийн төсөвт байсныг тухайн яамдын төсөвт шилжүүлсэнтэй холбоотойгоор Баянхонгор аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 3,870.8 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох дэмжлэгийг 794.4 сая төгрөгөөр бууруулж, өмнөх оны төсвийн үлдэгдлээс 3,239.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. Аймгийн 2022 оны төсвийн суурь зарлагын эх үүсвэр

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Сангийн яамны хянасан дүн	2022 он	
			Анх батлагдсан	Тодотгол-1
А	Б	1	2	3
	ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар	2021.11.15	2021.12.01	2022.05.25
1	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО	48,786.9	60,421.6	58,993.2
1.1	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	37,855.1	41,410.1	37,852.0
1.1.1	УРСГАЛ ОРЛОГО	16,286.3	19,821.4	20,134.0
1.1.1.1	Татварын орлого	13,805.0	16,536.8	16,617.2
1.1.1.2	Татварын бус орлого	2,481.3	3,284.6	3,
1.1.2	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	20.0	40.0	40.0
1.1.3	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	21,548.8	21,548.8	17,678.0
1.1.4	ӨМНӨХ ХЭМНЭГДСЭН ЗАРДАЛ, ТЭНЦЛИЙН АШИГ	0.0	0.0	0.0
1.1.5	ӨМНӨХ ОНЫ ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ		4,456.2	7,030.8
1.1.6	СУМДЫН ТУСГАЙ САНГУУД	10,931.8	14,555.3	14,110.4
1.1.7	ГАДААДЫН ТӨСЛИЙН ЗЭЭЛЭЭС	0.0	0.0	0.0
2	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА	48,786.9	60,421.6	58,993.2
2.1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,786.9	60,421.6	58,993.2
2.1.1	УРСГАЛ ЗАРДАЛ	37,372.5	44,232.2	42,342.8
2.1.1.1	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,144.1	43,102.1	41,183.5
2.1.1.2	ХҮҮ	0.0	0.0	0.0
2.1.1.3	ТАТААС	48.0	48.0	32.0
2.1.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,180.4	1,082.0	1,127.3
2.1.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,414.4	16,189.5	16,650.4
2.1.3	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ			
3	УРСГАЛ ТЭНЦЭЛ	-21,086.15	-24,410.78	-22,208.81
4	НИЙТ ТЭНЦЭЛ	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль, Баянхонгор аймаг, сумын ИТХ-ын тогтоолууд

Аймгийн Засаг дарга 2022 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан аймгийн төсөвт 2022.12.15-ны А/745 дугаар захирамжаар зохицуулалт хийжээ. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1², 42.2.2³ дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаал “Төсөвт зохицуулалт хийх журам”, аймгийн ИТХ-ын 2022.05.25-ны өдрийн “Аймгийн 2022 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 9/24 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл

² “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно” 42.2.1.төсвийн ерөнхийлөн захирагч нь:

³ “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд”

арга хэмжээний хэмнэгдсэн зардлаас 140.0 сая төгрөгийг хасаж, аймаг, сумдын 38 байгууллагын шаардлагатай зардалд төсөв хооронд зохицуулалт хийсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны орлогыг аймгийн ИТХ-аар 20,254.0 сая, сумын ИТХ-аар 38,739.2 сая, нийт 58,993.2 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянбулаг сумын ИТХ-ын 2022.06.09-ны өдрийн 7/03 дугаар хуралдааны тогтоолоор сумын татварын орлогын төлөвлөгөөнд малын тоо толгойн албан татварыг 20.0 сая төгрөгөөр баталсан байхад Баянбулаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг орхигдуулан Э-тайланд нэгтгүүлсэн байна.

- Баянцагаан сумын ИТХ-ын 2022.06.07-ны өдрийн 09 дугаар тогтоолоор хог хаягдлын хураамжийн орлого 30.0 сая төгрөгөөр баталсныг өөрчилж 16.0 сая, ус рашаан ашигласны төлбөрийн 14.0 сая төгрөг оруулахаар тодотгон баталсан байхад аймгийн ТЕЗ-ийн 2022 оны татварын орлогын төлөвлөгөө, аймгийн Татварын хэлтсийн татварын орлогын төлөвлөгөөнд тус тогтоолын өөрчлөлтийн оруулаагүй байна.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-т сумын ИТХ-аар тодотгон баталсан тогтоолыг өөрчлөлтийг тухай бүр санхүүгийн төлөвлөлтийг программд оруулан зөв нэгтгэж байх зөвлөмжийг хүргүүлж байна.

1.2 Татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, гүйцэтгэл

Татварын болон татварын бус орлогыг өмнөх оны гүйцэтгэл, Сангийн яамнаас хянасан дүн, мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн судалгаанд үндэслэн төлөвлөсөн бөгөөд урсгал орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 2,812.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар аймаг, сумдын ИТХ-аар 58,993.2 сая төгрөгийн нийт эх үүсвэрийг баталж, гүйцэтгэлээр 53,263.2 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэн ажилласан байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар татварын орлого 21,757.6 сая, улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг 17,678.0 сая, ОНХНС-аас авсан санхүүжилт 10,113.3 сая, төсөвт байгууллагын өөрийн орлого 1,776.4 сая, хүү торгуулийн орлого 1,937.9 сая төгрөг орсон байна.

Аудитын илрүүлэлт:

- Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийг Төрийн сан дахь 10030000972 тоот харилцах дансны гүйлгээтэй тулган шалгахад 2022 онд 17,126.2 сая төгрөгийн дэмжлэгийг хүлээн авч Сангийн сайдын 2022.02.08-ны өдрийн 33 дугаар “Дамжуулан зээлдүүлсэн зээлийн өр төлбөрийг суутган тооцох тухай” албан бичгийг үндэслэн /OL-2301MON-04 дугаарт зээл/ 483.2 сая төгрөгийн үндсэн зээл, 65.6 сая төгрөгийн хүү нийт 548.8 сая төгрөгийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс суутган тооцсон байна. Үүнээс шалтгаалж 8 сумын санхүүгийн дэмжлэг 184.4 сая, аймгийн төсөвт орох санхүүгийн дэмжлэг 364.4 сая төгрөгөөр дутуу орсон байна. Иймд дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрийг аймгийн төсөвт тусгайлан баталж хэрэгжүүлэх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Хүснэгт №2 сумдад олгосон санхүүгийн дэмжлэг

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Аймгийн ИТХ-ын 2022.05.25-ны өдрийн 9/24 тогтоол	Олгосон санхүүгийн дэмжлэг	Дутуу олгосон санхүүжилт
1	Баацагаан	593.4	553.4	40.0
2	Баянбулаг	570.0	560.0	10.0
3	Баянговь	487.3	487.3	-
4	Баянлиг	669.0	669.0	-
5	Баян-Овоо	(241.4)	(241.4)	-
6	Баян-Өндөр	492.3	492.3	-
7	Баянхонгор	(713.6)	(713.6)	-

8	Баянцагаан	563.3	516.3	47.0
9	Богд	584.8	581.8	3.0
10	Бөмбөгөр	356.2	356.2	-
11	Бууцагаан	824.6	824.6	-
12	Галуут	528.9	528.9	-
13	Гурванбулаг	496.2	483.3	12.9
14	Жаргалант	555.7	555.7	-
15	Жинст	656.2	656.2	-
16	Заг	515.8	497.1	18.7
17	Өлзийт	626.9	592.6	34.3
18	Хүрээмарал	562.5	562.5	-
19	Шинэжинст	393.7	393.7	-
20	Эрдэнэцогт	634.7	616.2	18.5
	Аймгийн дүн	9,156.5	8,972.1	184.4
21	Аймгийн төсөв	8,521.5	8,157.1	364.4
	Нийт	17,678.0	17,129.1	548.8

Татварын орлого

Тайланд онд нийт орлогыг 20,144.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс татварын орлогыг 16,617.2 сая, татварын бус орлогыг 3,111.3 сая, хөрөнгийн орлогыг 40.0 сая, хандив тусламжийн орлогыг 40.0 сая төгрөг төлөвлөж гүйцэтгэлээр 25,903.6 сая төгрөг орж нийт орлогын төлөвлөгөө 5,769.6 сая төгрөгөөр давуулсан биелсэн байна.

Хүснэгт 3. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлт

сая төгрөг

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2022 он		
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	НИЙТ ОРЛОГО	17,809.0	20,144.0	25,903.6	5,759.6
2	Татварын орлого	15,179.4	16,617.2	21,685.3	5,068.1
3	Орлогын албан татвар	9,706.9	10,720.8	11,933.7	1,212.9
4	Хөрөнгийн албан татвар	1,085.9	2,332.2	2,136.9	(195.3)
5	Бусад татвар, төлбөр, хураамж	4,386.7	3,564.2	7,614.7	4,050.6
6	Татварын бус орлого	2,485.6	3,111.3	3,840.3	729.0
7	Хөрөнгийн орлого	60.0	40.0	72.3	32.3
8	Тусламжийн орлого	84.0	375.5	305.7	(69.9)

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2022 оны татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг аймгийн Татварын хэлтсийн 2022 оны аймгийн төсвийн болон сумдын төсвийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг аудитын явцад тулган шалгав.

Аудитын илрүүлэлт:

-Тайлант онд аймгийн төсөвт орох татварын орлогыг 2,089.3 сая, сумын төсөвт орох татварын орлогыг 14,527.9 сая нийт 16,617.2 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 21,685.3 сая төгрөгийн татварын орлогыг ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан бол аймгийн Татварын хэлтсийн 2022 оны тайлангаар татварын орлогын гүйцэтгэлийг 21,808.6 сая төгрөгөөр тайлагнаж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас 123.3 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Үүнд:

-Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн даргын 2022.04.26-ны өдрийн А/19 дугаар “Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт авах татвар төлөгчдийн жагсаалт батлах тухай” тушаалыг үндэслэн олгосон 593.2 сая төгрөгөөр Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хувь хүний орлогын албан татварыг бууруулсан.

-Баянхонгор аймгийн Татварын хэлтэс 2023.01.01-нд орсон замд яваа татвар 173.6 сая төгрөгийг 2022 оны татварын орлогоор тайлагнасан бол аймгийн Засаг даргын 2022 оны

санхүүгийн нэгтгэсэн тайланд татварын орлогыг мөнгөн сууриар бүртгэснээс тус тус шалтгаалсан байна.

Хүснэгт 4. Замд яваа татварын дүн сая төгрөгөөр/

№	Татварын нэр төрөл	Замд яваа мөнгөн хөрөнгө
1	110001 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	74.9
2	110002 Үйл ажиллагааны орлого	14.8
3	110003 Хөрөнгийн орлого	33.1
4	113001 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2.1
5	113002 Бууны албан татвар	0.2
6	113003 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1.8
7	113004 Малд ногдуулах албан татвар	10.9
8	118001 Улсын тэмдэгтийн хураамж	0.0
9	118009 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	0.5
10	118011 Бусад татвар	0.7
11	118101 Газрын төлбөр	4.8
12	118201 Ойн нөөц ашигласны төлбөр	0.5
13	118203 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	30.4
14	Нийт	173.6

Тайлант онд төлөвлөсөн татварын орлогыг 16,617.2 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 21,685.3 сая (130.0%) биелүүлсэн бөгөөд ан, амьтан агнуурын нөөц ашигласны орлого 494 хувь, газрын дуудлага худалдааны орлого 158 хувь, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого 128 хувь, газрын төлбөр, дуудлага худалдаа, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого, улсын тэмдэгтийн хураамж, орон нутгийн зам ашигласны хураамжийн орлогыг 104.5-160.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 5. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Татварын орлого	16,617.2	21,685.3	5,068.1
2	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	7,269.0	9,278.4	2,009.4
3	Үйл ажиллагааны орлого	1,215.0	1,244.3	29.3
4	Хөрөнгийн орлого	1,690.0	1,041.5	(648.5)
5	Хөрөнгө борлуулсны орлого	400.0	370.7	(29.3)
6	ААНОАТ	740.0	592.0	(148.0)
7	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	400.0	388.1	(11.9)
8	Бууны албан татвар	55.0	51.0	(4.0)
9	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	640.0	654.9	14.9
10	Малд ногдуулах албан татвар	1,237.2	1,043.0	(194.3)
17	Улсын тэмдэгтийн хураамж	305.0	415.5	110.5
18	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	50.0	42.9	(7.1)
19	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	761.3	790.9	29.6
20	Бусад татвар	280.0	357.1	77.1
21	Газрын төлбөр	460.0	381.0	(79.0)
22	Дуудлага худалдаа	200.0	315.2	115.2
23	Ойн нөөц ашигласны төлбөр	-	0.5	0.5
24	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	921.7	4,556.5	3,634.8
25	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	586.2	521.5	(64.7)
26	Бусад татвар	-	233.6	233.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2022 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн орлого давж биелэхэд дараах татварын орлого голлох нөлөөг үзүүлсэн байна. Үүнд:

- Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар 2,009.4 сая төгрөгөөр давж биелсэн нь 2022 онд боловсролын салбарын ажиллагсдын цалинг нэг шатлалтай болгон өөрчилсөн, Засгийн газрын 2022 оны 107 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин нэмсэн зэргээс шалтгаалсан байна.

- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 921.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 4,556.5 сая төгрөгийг сумын төсөвт төвлөрүүлж 3,634.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн. Үүнд: 2022 онд БОАЖЯамнаас 134 шонхор агнах зөвшөөрөл олгосны үндсэн дээр Баянбулаг, Заг, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Өлзийт, Жаргалант, Гурванбулаг, Эрдэнэцогт, Баацагаан, Бууцагаан, Хүрээмарал, Бөмбөгөр сумдын Засаг дарга нар тусгай зөвшөөрөл бүхий этгээдтэй идлэг шонхрын гэрээ байгуулан орлогыг сумын төсөвт оруулсантай холбоотой байна.

Тайлант онд төлөвлөсөн татварын орлогыг биелүүлж ажилласан ч аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, малын тоо толгойн албан татвар, газрын төлбөр зэрэг зарим татварын орлогын төлөвлөгөө биелээгүй нь байна.

- Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн тайлангаар 2022 онд ААНОАТ 986.2 сая төгрөг орсноос улсын төсөвт аж ахуйн нэгжүүдийн өмнөх оны татварын өглөг 842.6 сая төгрөг төвлөрч, аймгийн төсөвт 143.7 сая төгрөг орсон байна. Харин ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 740.0 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 592.0 сая төгрөг байгаа нь аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн тайлбарт 2022 оны эцэст улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 548.8 сая төгрөгийг дамжуулан зээлдүүлэх гэрээний зээл, хүүгийн төлбөрт суутган тооцсоноос аймгийн төсөвт хүндрэл учирч 2023 оны ААНОАТ-ын аймагт орох орлогоос 448.3 сая төгрөгийг урьдчилан авч ААНОАТ-ын орлогоор тайлагнаснаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.1-д заасны дагуу Сангийн яамнаас 2022.12.26-ны өдөр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 2023 онд орох орлогоос 448.3 сая төгрөгийг авч аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд урьдчилж орсон орлогоор, харин орлогын гүйцэтгэлд ААНОАТ-ын орлогоор бүртгэж тайлагнасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх; 6.2.3.урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд 562 аж ахуйн нэгж, байгууллага 2022 оны жилийн эцсийн ААНОАТ-ын ногдуулалтаар 992.6 сая төгрөг төлөхөөр тайлагнасан, Үүнээс орон нутгийн төсөвт 40 хувь буюу 397.0 сая төгрөг орохоор байна. Гэвч 2023 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос 448.3 сая төгрөг урьдчилж авсан нь 2023 онд орон нутгийн төсвийн татварын орлого бүрэн төвлөрөхгүй байх эрсдэлтэй байна.

Иймд 2023 онд орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөж зарцуулах зөвлөмжийг аймгийн Засаг дарга, аймгийн Татварын хэлтсийн даргад зөвлөмжөөр хүргүүлж байна.

- Малын тоо толгойн албан татварын хууль баталснаар орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалт, цөлжилт, худаг усны хангамж зэрэг асуудлаа бие даан шийдвэрлэх боломжийг олгосон. Аймгийн Татварын хэлтсээс үүсгэсэн малчин өрх мал бүхий 13591 татвар төлөгчөөс 1,260.7 сая төгрөгийн малын тоо толгойн албан татварын ногдуулалтыг нэхэмжлэх үүсгэсэн байхад тайлант онд 1,237.2 сая төгрөг төлөвлөж, 1042.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 6. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Сумдын нэр	Татвар төлөгчийн тоо	Нэхэмжлэхийн дүн	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт хувь
Баацагаан	974	85.1	84.3	63.1	75%
Баянбулаг	384	25.2	20.0	20.1	101%
Баянговь	744	41.1	34.0	32.0	94%
Баянлиг	485	20.2	65.0	97.4	150%
Баян-Овоо	755	160.9	150.0	93.0	62%
Баян-Өндөр	646	59.4	70.0	51.1	73%
Баянхонгор	984	88.0	38.5	28.4	74%
Баянцагаан	748	114.6	133.3	92.2	69%
Богд	556	51.7	59.9	56.2	94%
Бөмбөгөр	942	75.4	74.5	47.7	64%
Бууцагаан	905	79.5	80.1	58.0	72%
Галуут	1046	114.9	100.0	83.4	83%
Гурванбулаг	517	26.8	33.0	10.3	31%
Жаргалант	679	55.0	36.2	49.1	136%
Жинст	540	76.5	79.2	65.0	82%
Заг	535	36.9	20.0	21.3	107%
Өлзийт	73	4.3	7.5	84.6	1132%
Хүрээмарал	447	35.6	37.3	24.6	66%
Шинэжинст	476	26.8	36.0	26.8	75%
Эрдэнэцогт	1155	82.9	78.5	54.4	69%
ДҮН	13591	1,260.7	1,237.2	1,058.8	86%

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2022 оны татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Малын тоо толгойн албан татварыг Баянбулаг, Баянговь, Баянлиг, жаргалант, Заг, Өлзийт, Хүрээмарал, Богд сумаас бусад сумд 31-86 хувийн гүйцэтгэлтэй байгаагаас Баян-Овоо сум 57.0 сая, Баянцагаан сум 41.0 сая, Эрдэнэцогт сум 24.1 сая, Бөмбөгөр сум 26.8 сая, Бууцагаан сум 22.0 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар малын тоо толгойн албан татварыг нэхэмжлэхийн дагуу төлөвлөж батлаагүй, баталсан орлогыг сумын төсөвт бүрэн төвлөрүүлээгүй зэрэг зөрчлийг арилгах 333.6 сая төгрөгийн 14 албан шаардлага, 102.6 сая төгрөгийн 7 зөвлөмжийг хүргүүлсэн.

Аудитын илрүүлэлт:

Малын тоо толгойн албан татварыг зарим сумд бодитой төлөвлөөгүй байна. Тухайлбал Өлзийт сум 7.5 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 84.6 сая төгрөг, Баянлиг сум 65.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 97.4 сая төгрөг орсон.

Иймд малын тоо толгойн албан татварыг жилийн эцсийн мал тооллогын статистик мэдээ, Татварын хэлтсээс үүсгэсэн нэхэмжлэх, өмнөх оны орлогын гүйцэтгэл зэрэгтэй уялдуулан үндэслэлтэй төлөвлөх, хяналт тавьж ажиллах зөвлөмжийг сумын Засаг дарга нарт хүргүүлж байна.

- Газрын төлбөрийн орлого 79.0 сая төгрөгөөр тасарсан нь Баянхонгор сум газрын төлбөрийг 126.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 90.7 сая төгрөг оруулж, 35.2 сая төгрөгөөр тасарсан нь Баянхонгор тохижилт үйлчилгээ төсөвт байгууллагын газарт 39.1 сая төгрөгийн ногдуулсан боловч тус байгууллагын төсөвт батлаагүй, Өлзийт сум Баянхонгор сумын ЗДТГ-ын сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийн газрын төлбөр 6.3 сая, аймгийн Цагдаагийн газрын /Өлзийтийн пост/-ын 1.0 сая төгрөгийн ногдуулалт хийсэн ч төсөвт төвлөрүүлээгүй байна.

Ус рашаан ашигласны төлбөр 64.7 сая төгрөгөөр тасарсан нь 30.4 сая төгрөг нь тухайн тайланд хугацаанд ороогүй, ашиглалтын лицензтэй ААНБ-ууд нь Байгаль орчин аялал жуулчлалын яаманд уулын ажлын төлөвлөгөөгөө батлуулахдаа ус ашиглах төлбөрийн дүгнэлт гаргуулан ирүүлдэг. Харин орон нутагт үйл ажиллагаа явуулахдаа ус ашиглалтыг тоолуурын заалтаар тооцож, усны төлбөрийг ногдуулан төлж байгаа нь усны төлбөр төлөх төлбөрийн хэмжээ ихээхэн багассан, ашиглалтын лицензтэй ААНБ-ууд нь баталсан уулын ажлын төлөвлөгөөндөө хүрч ажилладаггүй, төлөвлөсөн цаг хугацаандаа үйл ажиллагаа явуулдаггүй улмаас усны төлбөрийн татварын орлогын бүрдүүлэлтэд нөлөөлж орлогын төлөвлөгөө тасалдахад хүрсэн.

Галт зэвсгийн албан татварын төлөгчдийн бүртгэлийн сантай тулган бүртгэлийн зөрүүг арилгах, татвар төлөгчийг татварт хамруулах ажлыг зохион ажилласан ба орлогын төлөвлөгөөний биелэлт болон галт зэвсгийн тооллого нэгдсэн арга хэмжээг Баянхонгор, Баянбулаг, Эрдэнэцогт, Гурванбулаг, Өлзийт зэрэг сумд хангалтгүй зохион байгуулж ажилласантай холбоотой гэсэн тайлбарыг аймгийн Татварын хэлтсийн 2023.04.07-ны өдрийн 139 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Татварын бус орлого

Татварын бус орлогоор 3,111.3 сая төгрөгийн баталснаас гүйцэтгэлээр 3,714.4 сая төгрөг орсон байна.

Хүү торгуулийн орлогоор аймаг, сумд 1,648.4 сая төгрөг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,937.9 сая төгрөг оруулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг Сангийн яамнаас 20.0 сая төгрөгөөр хянаж ирүүлснийг 20.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.12.01-ний өдрийн 6/24 дугаар тогтоолоор 40.0 сая төгрөгөөр баталжээ. Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор Эрдэнэцогт, Жинст сумын Соёлын төвийн барилга, Жинст сумын орон сууцны барилга, Номун далай цогцолбор сургуулийн хуучин барилга, Баян-Овоо сумын ИТХ, ЗДТГ-ын 3 суудлын автомашин, 1 пад трактор, Цагдаагийн газрын 2 автомашин, Сум дундын ойн ангийн пургон машиныг дуудлага худалдаанд оруулан 67.1 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн өмчийн газар төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2022.07.22-ны өдрийн А/493 дугаар захирамжаар “Виртуал студи” -ын барилга, тоног төхөөрөмжийг хувьчлах сонгон шалгаруулалтын журам баталсан. Сонгон шалгаруулалтаар “Айети Юнипикэшн” ХХК шалгарч аймгийн ОНӨГ-ын даргатай 2022.09.29-ны өдөр “Баянхонгор аймгийн Баянхонгор

сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй виртуал студийг менежментээр хувьчлах гэрээ” байгуулан 177.0 сая төгрөгийн өртөгтэй барилга, 73.0 сая төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмжийг 2022.09.29-ны өдрөөс 8 жилийн хугацаанд эргэн төлөхөөр гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн. 2022 онд Айти Юнипикэшн” ХХК-иас 25.2 сая төгрөг төвлөрснийг орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогоор бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга, “Айти Юнипикэшн” ХХК-ийн хооронд байгуулсан “Виртуал студийг менежментээр хувьчлах гэрээ”-ний зээлийн эргэн төлөлтийн графикт 2022оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс сар бүр 2.3 сая төгрөг төлөхөөр тусгасан байхад 2022 оны 10-12 сарын төлөлт 7.0 сая төгрөгийг аймгийн Орон нутгийн өмчийн газрын Төрийн сан банкин дах 10000051006 тоот дансанд төвлөрүүлээгүй байна.

Иймд “Айти Юнипикэшн” ХХК-уар 7.0 төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт тогтоож цаашид гэрээний үүргээ сар бүр биелүүлж байх нь зүйтэй.

- Бөмбөгөр суманд уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч Вояжерминерал ресурсес, Ай Эн Ди, Эрдэнэ цагаач, Эл Ту Ди, Хишигт хөндий, Одод гоулд ХХК-уудад газрын төлбөрийн нэхэмжлэлийг биечлэн цаасаар, цахимаар, утсаар 4-5 удаа хүргүүлсэн боловч 42.9 сая төгрөгийн төлбөрийг төлөөгүй байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/24 дүгээр тогтоолоор төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 9,156.5 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 5,811.1 сая төгрөгөөр баталсан байна.

Сумдын дүнгээр нийт 38,739.6 сая төгрөг баталж төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 734.1 сая төгрөгөөр баталснаас Баянхонгор сумын ЗДТГ 709.4 сая, бусад сумдын ЗДТГ 24.7 сая төгрөг оруулахаар төлөвлөжээ.

Хүснэгт 7. Сумдын төсвийн эх үүсвэрийн судалгаа /сая төгрөгөөр/

Санхүүжилтийн эх үүсвэр	Мөнгөн дүн	Хувь
Төсөвт байгууллагуудын өөрийн орлого	734.1	1.9%
СХС-ийн зээлийн эргэн төлөлт орлого	1,491.7	3.9%
ОНХС-ийн сангаас санхүүжих	5,811.1	15.0%
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	6,313.5	16.3%
Татварын орлого	14,857.3	38.4%
Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	9,156.5	23.6%
ОНХС-ийн хандив тусламжийн орлого	375.5	1.0%
ДҮН	38,739.6	100%

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолууд

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний орлого

Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээний загварын 2.1.3 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг үндэслэн “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй харилцан тохиролцож уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 12 аж ахуйн нэгжтэй “Орон нутгийн хамтын ажиллагааны” гэрээ байгуулж аймагт 2,265.0 сая, сумдад 1,230.0 сая төгрөг нийт 3,570. сая төгрөгийн

гэрээ байгуулсан. Аймагт оруулах хөрөнгө оруулалтаар 2022 онд 1,465.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, их засвар, гудамж талбайн тохижилт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Дээрх хөрөнгө оруулалт нь аймгийн орон нутгийн төсвийн дансаар дамжуулаагүй, өмнөх онд ТЕЗ-ийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчил давтан гарсан байна.

Иймд уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ”-ний дагуу төвлөрөх орлогыг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлж Төсвийн тухай хуульд нийцүүлэн зарцуулж байх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

БҮЛЭГ 2 АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙГ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 22.2.44 ДЭХ ХЭСЭГ, 24.55, 24.66 ДАХЬ ЗААЛТЫН ДАГУУ БАТЛУУЛЖ, БАТЛАГДСАН ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ, ҮР ДҮНТЭЙ ЗАРЦУУЛСАН ЭСЭХ.

Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд харьяа 49 төсвийн байгууллага, 8 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 өрхийн эрүүл мэндийн төв, 42 тусгай сан, 20 сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нийт 123 байгууллагын санхүүгийн тайлан, 110 боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын байгууллагуудын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, гэрээт ажиллагчдын 2022 оны 1-4 сарын цалин, НДШ, урсгал засварын зардал, аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө, замын сан, техник хяналт, барьцаа, аймгийн ОНХС-ийн данс нийт 5 дансны гүйлгээ нэгтгэгдсэн байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.12.01-ний өдрийн 6/24 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор 2022 онд аймгийн төсвөөс зарцуулах зарлагыг нийт 60,421.6 сая төгрөгөөр, аймгийн ИТХ-ын 2022.05.25-ны өдрийн хуралдааны 9/24 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын тогтоолоор анхны батлагдсан төсвийг 1,428.4 сая төгрөгөөр төсвийг бууруулан нийт зардлыг 58,993.2 сая төгрөгөөр төсвийг баталсан.

Хүснэгт8 Аймаг, сумын ИТХ-аар баталсан 2022 оны нийт төсөв /сая төгрөг/

Үзүүлэлт	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	60,421.6	58,993.2	(1,428.43)
УРСГАЛ ЗАРДАЛ	41,865.6	39,631.7	(2,233.86)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,295.6	36,896.6	(2,399.03)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,757.7	12,078.1	(2,679.58)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,861.3	1,542.4	(318.89)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,936.8	11,587.1	(349.65)
Хангамж, бараа материалын зардал	2,569.0	2,711.6	142.62
Нормативт зардал	83.8	96.3	12.44
Эд хогшил, урсгал засварын зардал	558.8	726.5	167.67
Томилолт, зочны зардал	151.6	180.3	28.69
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,556.2	1,668.1	111.91
Бараа үйлчилгээний бусад зардал	5,820.4	6,306.2	485.77
ТАТААС	48.0	32.0	(16.00)
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	48.0	32.0	(16.00)

⁴ 22.2.4.хөтөлбөрөөр

⁵ 24.5.Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна.

⁶ 24.6.Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөв, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,522.0	2,703.2	181.17
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,450.0	1,575.9	125.90
Бусад урсгал шилжүүлэг	1,072.0	1,127.3	55.27
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,615.9	15,074.5	458.64
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,940.2	4,286.9	346.79
Сум хөгжүүлэх сан	3,623.5	3,970.3	346.79
Дамжуулан зээлдэхийн төлбөр	316.7	316.7	-

Эх сурвалж: Аймаг сумын 2022 оны ИТХ-ын тогтоол

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2022.04.29-ны өдрийн нэмэлт өөрчлөлт, боловсрол, соёл, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг орон нутгийн төсөвт байсныг тухайн яамдын төсөвт шилжүүлсэнтэй холбоотойгоор цалингийн зардал 2,678.5 сая төгрөг, НДШ-ийн зардал 318.9 сая төгрөгөөр, Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотойгоор байр ашиглалттай холбоотой зардлыг 349.7 сая, төрөөс олгох татаасыг 16.0 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 58,993.2 сая төгрөгийн төсөв батлагдаж 51,608.7 сая зарцуулснаас урсгал зардалд 37,188.3 сая, хөрөнгийн зардалд 11,515.4 сая, хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлд 2,536.2 сая, урт хугацаат дамжуулан зээлдүүлсэн зээлийн төлбөрт 548.8 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт№9 Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Б	3	4	5=4-3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	58,993.2	51,608.7	(7,384.5)
УРСГАЛ ЗАРДАЛ	39,631.7	37,188.3	(2,443.4)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,896.6	34,555.2	(2,341.4)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,078.1	11,604.6	(473.5)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,542.4	1,432.1	(110.3)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,587.1	10,978.7	(608.4)
Хангамж, бараа материалын зардал	2,711.6	1,955.8	(755.8)
Нормативт зардал	96.3	94.7	(1.6)
Эд хогшил, урсгал засварын зардал	726.5	708.0	(18.5)
Томилголт, зочны зардал	180.3	163.6	(16.7)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,668.1	1,568.9	(99.2)
Бараа үйлчилгээний бусад зардал	6,306.2	6,048.8	(257.4)
ТАТААС	32.0	26.5	(5.5)
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	32.0	26.5	(5.5)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,703.2	2,606.6	(96.6)
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,575.9	1,548.4	(27.5)
Бусад урсгал шилжүүлэг	1,127.3	1,058.2	(69.1)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,074.5	11,515.4	(3,559.1)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	4,286.9	2,905.0	(1,381.9)
Сум хөгжүүлэх сан	3,970.3	2,356.2	(1,614.1)
Дамжуулан зээлдэхийн төлбөр	316.7	548.8	232.2
АЖИЛЛАГСДЫН ТОО	786	740	-46
Удирдах ажилтан	203	185	-18
Гүйцэтгэх ажилтан	367	353	-14
Үйлчлэх ажилтан	153	150	-3
Гэрээт ажилтан	63	52	-11

Аудитын илрүүлэлт:

-Тайлант онд Сангийн яамнаас дамжуулан зээлдүүлсэн зээлийн үндсэн төлбөр 258.0 сая, хүүгийн төлбөр 58.7 сая нийт 316.7 сая төгрөгийг төлүүлэхээр зардлыг хянаж, аймгийн ИТХ-аар баталсан байхад 2022 оны 12 дугаар сард Сангийн сайдын 2022.02.08-ны өдрийн 33 дугаар “Дамжуулан зээлдүүлсэн зээлийн өр төлбөрийг суутган тооцох тухай” албан бичгийн үндэслэн OL-2301MON-04 зээлийн үндсэн зээлээс 483.2 сая, хүүгийн төлбөрт 65.6 сая нийт 548.8 сая төгрөгийн аймгийн улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс суутган тооцсон нь батлагдсан төсвийг 232.2 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар

зүйл 6.6.6. тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд дамжуулан зээлдүүлсэн зээлийн зээл, хүүгийн төлбөрийн тайланд онд аймгийн төсөвт баталсан дүнгээр төлбөрийн аливаа хэлбэрээр төлж барагдуулж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.12.01-ний өдрийн 6/23 дугаар “Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” тогтоолоор 7 үндсэн зорилтын хүрээнд 159 арга хэмжээг улс, аймгийн орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр бусад эх үүсвэрээс хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.12.01-ний өдрийн 6/24 дугаар “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” тогтоолоор 1,700.0 сая төгрөгийн 44 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2022.05.25-ны өдрийн хуралдааны 9/24 дугаар тогтоолоор аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан Жаргалтай амьдрал сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төвийн /Сэтгэц наркологийн тасгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх/ зардалд 90.0 сая төгрөг, “Хүмүүнлэгийн ордон”-ы тохижилт, үйлчилгээг сайжруулахад 12.8 сая төгрөг нэмж, шинээр 4 төсөл арга хэмжээнд 86.0 сая төгрөгийг нэмж баталсан.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн Засаг дарга 2022 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан аймгийн төсөвт 2022.12.15-ны А/745 дугаар захирамжаар аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээний хэмнэгдсэн зардлаас 140.0 сая төгрөгийг хасаж, 2022.12.31-ны А/759 дугаар захирамжаар “Хүмүүнлэгийн ордон”-ы үйл ажиллагааны зардалд 1.9 сая төгрөгийг нэмэгдүүлэн олгож аймгийн ИТХ-аас тогтоосон төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Иймд Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн “41.2.2. батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах,” албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

Орон нутгийн хөгжлийн сан:

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд улсын төсвөөс Баянхонгор аймагт олгох орлогын шилжүүлгийг 10,931.8 сая төгрөг, үүнээс аймгийн ОНХС-д 4,192.2 сая, сумдын ОНХС-д 6,206.8 сая, урсгал зардалд 532.9 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг олгохоор баталсан ба энэ хуулийн 2022.04.29 өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 791.3 сая төгрөгөөр бууруулан 10,140.5 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг олгохоор хуульчилсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/24 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн олгох орлогын шилжүүлгийг 3,796.5 сая, аймгийн ОНХС-д бусад эх үүсвэрээс 944.2 сая, зураг төсвийн орлого 250.0 сая нийт 4,990.7 сая төгрөг, мал эмнэлэг, хот тохижилтын урсгал зардалд 532,9 сая, сумдад олгох ОНХС-ийн дэмжлэг 5,811.1 сая, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор өмнөх оны харилцах дансны үлдэгдлээс 1,366.9 сая, хандив тусламжийн орлогоор 375.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр, малын тоо толгойн албан татварын орлогоор 1,514.9 сая нийт 3,257.3 сая төгрөгийг тус тус баталсан байна.

Гүйцэтгэлээр ОНХС-аас 10,113.3 сая төгрөг, малын тоо толгойн албан татвар болон бусад эх үүсвэрээс 1,683.7 сая, хандив тусламжийн орлого 433.9 сая, зураг

төсвийн орлого 125.9 сая, өмнөх оны харилцах дансны үлдэгдлээс 1642.8 сая нийт 13,999.6 сая төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн байна.

Хандив тусламжийн орлогоор нийт 375.5 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн нь уул уурхайн компаниудын хандивын орлогоор Галуут сум 39.5 сая, Баян-Овоо сум 198.0 сая, Шинэжинст сум 75.1 сая төгрөг, өвс тэжээлийн орлогоор Жаргалант сум 19.4 сая, Хүрээмарал сум 43.5 сая төгрөг оруулахаар баталснаас гүйцэтгэлээр хандивын орлогоор 257.8 сая, өвс тэжээлийн орлогоор 48.2 сая төгрөг орсон байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.12.01-ны өдрийн 6/24 дугаар тогтоолоор улсын төсвөөс аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 4,192.2 сая, зураг төсвийн орлогоос 250.0 сая, суурь орлого 100.0 сая төгрөг нийт 4,542.2 сая төгрөгийн эх үүсвэрээр шилжих 16 төсөл арга хэмжээнд 2,013.6 сая, шинээр хэрэгжүүлэх 14 төсөл арга хэмжээнд 2,528.6 сая, нийт 4,542.2 сая төгрөгийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.05.25-ны өдрийн 9/24 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн олгох орлогын шилжүүлгийг 3,796.5 сая, орон нутгийн төсвөөс 672.1 сая, суурь орлогыг 100.0 сая, зураг төсвийн орлогыг 250.0 сая төгрөгөөр нийт 44 төсөл арга хэмжээг 4,990.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж гүйцэтгэлээр 4,570.5 сая төгрөгийн зардал гарсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 2 төсөл арга хэмжээнд 279.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байхад дуусаагүй ажлыг хүлээлгэж өгөөгүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байгаа нь нь Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1-т гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэх, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8 дугаар зүйлийн 8.5-т “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д зааснаар захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу аймаг, нийслэлийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан нэгж, сум, дүүргийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан албан тушаалтан нь бодит гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийн эрхийг олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна

Аудитын илрүүлэлт:

- Богд сумын Далан түрүүний 3 дугаар багийн төвийн барилгын ажил 99.6 сая төгрөгөөр хийгдэхээр “Ханзол” ХХК-тай гэрээ хийсэн боловч өмнөх онд 85.0 сая, тайланд онд 14.5 сая төгрөгийг барьцаа хөрөнгө оруулалтын данс руу шилжүүлсэн боловч ажлыг дуусгаж хүлээлгэж өгөөгүй

- Эрдэм сургуулийн гаднах спорт цогцолбор талбайн ажлыг 124.6 сая төгрөгөөр гүйцэтгэхээр “Гал гэрэл констракшн” ХХК-тай гэрээг байгуулж өмнөх онд 109.4 сая төгрөг олгосон ба 2022 оны 10 дугаар сарын 11-ны өдөр 70.2 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж тайлант онд 85.3 сая төгрөг олгосон байхад ажлыг дуусгаж хүлээлгэн өгөөгүй.

Иймд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дээр 2 ажлын 2023 оны 3 дугаар улиралд багтаан ажлыг дуусган хүлээлгэн өгөх, түүнд аймгийн ЗДТГ-ын ХБХОХэлтэс хяналт тавьж хүлээн авах албан шаардлагын аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлэв.

Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар ОНХС-ийн үйл ажиллагаатай холбоотой 139.0 сая төгрөгийн алдаа илэрч санхүүгийн тайланд залруулсан, нийт 1,152.9 сая төгрөгийн 36 зөрчил илэрснээс 32.3 сая төгрөгийн 8 төлбөрийн акт, 370.8 сая төгрөгийн 8 албан шаардлага, 750.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд:

- Баянцагаан сумын ОНХС-аас сумын Засаг даргын 2022.12.23-ны өдрийн А/129 дүгээр захирамжаар 15.0 сая төгрөгийн өртөг бүхий ногоон байгууламж, 2022.11.14-ний өдрийн А/100 дугаар захирамжаар 20.0 сая төгрөгийн өртөг бүхий Дэлгэрэх 2 дугаар багийн төвийн засварын ажил, 2022.12.23-ны өдрийн А/131 дүгээр захирамжаар 20.0 сая өртөг бүхий цөм сургийн өвөлжөө барих барилгын материалыг орлого аваагүй байна. Мөн Баянцагаан сумын Орон нутгийн хөгжлийн сан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 189.4 сая төгрөгийн өртөг бүхий Цэцэн 3 дугаар багийн төвийн засварын ажлыг гүйцэтгүүлэхээр Шинэ өлгийн зам ХХК-тай 188.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд гэрээнд зураг төсвийн үнэ болох 3.0 сая төгрөгийг санхүүжилтээс суутган тооцоо хийгээгүй зөрчил илэрч тусгаагүй, мөн суутган тооцоогүй байна.
- Баянцагаан сумын ОНХС ЦЭСДА ХХК-иар гүйцэтгүүлсэн 12.0 сая төгрөгийн өртөг бүхий Хаус хорооллын зураг төсөв, 7.0 сая төгрөгийн өртөг бүхий Спорт заалны засварын зураг төсвийг авлагаар тайлант тусгаагүй байна.
- Баянцагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 189.4 сая төгрөгийн өртөг бүхий Цэцэн 3 дугаар багийн төвийн засварын ажлыг гүйцэтгүүлэхээр Шинэ өлгийн зам ХХК-тай 2022.07.18-2022.10.01-ний өдрийн хугацаанд гүйцэтгэхээр 188.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан ч уг ажлыг дуусгаагүй, гэрээг сунгаагүй, хүлээж аваагүй байна.
- Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сан шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 9-12 дугаар сард мэдээллийг байршуулаагүйгээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 67.6 сая төгрөгийн 7 худалдан авалтыг мэдээлээгүй, тайланд онд байгуулсан 13 гэрээ, мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.
- Баянцагаан сумын ОНХС-аас хэрэгжсэн Соёл амралтын хүрээлэнгийн тохижилтын ажлыг иргэн Д.Батдоржоор гүйцэтгүүлэхээр 20.0 сая төгрөгийн гэрээ хийсэн бөгөөд зураг төсвийн үнэ болох 1.0 сая төгрөгийг гүйцэтгэгчээс суутгаагүй байна.
- Жаргалант сумын ОНХС-ийн хөрөнгөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан 9 аж ахуйн нэгжид 191.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгохдоо и-баримтыг үндэслэн гүйлгээг хийгээгүй атлаа татварыг суутган тооцож, орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй байна.
- Жаргалант сумын Орон нутгийн хөгжлийн сан Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ажил гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгжүүдэд зардлыг шилжүүлэхдээ тооцооны дансаар дамжуулалгүй, шууд зардлаар тайлагнасан байна. Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажилд шууд гэрээ байгуулж, гүйцэтгэхдээ сумын Засаг дарга захирамж гаргаагүй байна.

Техник хяналт, барьцаа хөрөнгө оруулалтын данс

Төрийн сан дахь 100030051350 тоот Бх.Барьцаа хөрөнгө оруулалт дансны мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 6,212.2 сая төгрөг, тайлант хугацаанд 1,931.4 сая төгрөгийн орлого төвлөрч, 4,027.9 сая төгрөгийн зарцуулалт гарч, оны эцсийн үлдэгдэл 4,115.7 сая төгрөг байна.

Барьцаа хөрөнгийн дансанд УТХО, аймгийн ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 18 төсөл арга хэмжээний 1,931.4 сая төгрөг төвлөрснөөс чанарын баталгаа 478.9 сая, дуусаагүй 3 ажлын 1,452.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт№10 Барьцаа хөрөнгө оруулалтын дансны орлого, зарлагын гүйлгээ

Д.Д	Хөрөнгө оруулалтын ажлын нэр	Байршуулсан дүн	Үүнээс: Чанарын баталгаа	Дуусаагүй ажлын санхүүжилт
1	УТХО-аар хэрэгжсэн ТАХ	1,537.1	84.6	1,452.5
2	Бусад эх үүсвэрээр хэрэгжсэн ТАХ	394.3	394.3	
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	1,931.4	478.9	1,452.9

Барьцаа хөрөнгийн данснаас буцаан олгосон чанарын баталгааны мөнгө 3,881.3 сая, техник хяналтын зардал 48.7 сая, нормчлолын зардал 2.9 сая, зураг төсөв, зохиогчийн хяналтын зардал 27.7 сая ОНХС-д буцаан олгосон санхүүжилт 67.4 сая, нийт 4,027.9 сая төгрөг зарцуулжээ.

Төрийн сан дахь 100030051370 тоот Бх.Техник хяналт зардлын дансанд оны эхэнд 528.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант хугацаанд 634.8 сая төгрөг төвлөрч, 783.8 сая төгрөгийн зарцуулалт гарч оны эцэст 379.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/785 дугаар захирамжаар гамшгийн нөхцөл байдал /Ковид-19 цар тахал, 10 суманд үүсээд байгаа шүлхий/ хүндэрсэнтэй холбоотойгоор Техник хяналтын зардлаас 2 суудлын автомашин худалдан авахаар Таван богд ХХК-ийн дансруу 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр 121.1 сая, 2022 оны сарын 03 сарын 22-ны өдөр 121.1 сая төгрөгийг тус тус шилжүүлсэн байна. Аймгийн ЗДТГ-аас томилсон ажлын хэсэг дээр 2 автомашиныг хүлээн авсан ба тус хөрөнгө 2022 оны жилийн эцэст Аймгийн ЗДТГ-т хөрөнгөнд бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 04 сарын 26-ны өдрийн 85 дугаар тушаалын хавсралт "Барилгын захиалагчийн хяналт хийхтэй холбогдон гарах зардлын нэр төрөл"-ийг зөрчсөн тул зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлээ.

- Техник хяналтын зардлаас аймгийн Засаг даргын 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн а/342 дугаар захирамжаар БНСУ-ын Ичон хотод албан ёсны айлчлал хийхээр 2022 оны 5 сарын 4-ний өдөр МИАТ ХХК-ийн дансанд тийзний үнэд 6.4 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 04 сарын 11-ны өдрийн 83 дугаар тушаалын хавсралт "Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэх зардлын нэр төрөл"-ийг зөрчсөн тул буруутай албан тушаалтанаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Замын сан:

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.12.01-ны өдрийн 6/24 дугаар тогтоолоор АТБӨЯХАТ-ыг 280.0 сая, орон нутгийн авто зам ашигласны төлбөр 570.0 сая, торгуулийн орлогыг 600,0 сая төгрөгийг оруулахаар санхүүгийн эх үүсвэрийг баталж, аймгийн ИТХ-ын 2022.05.25-ний өдрийн 9/24 тогтоолоор өмнөх оны үлдэгдэл 125.9 сая төгрөгийг нэмж тодотгон нийт 1,575.9 сая төгрөгийн эх үүсвэрийг төлөвлөж, өмнөх оноос шилжих 3 төсөл, арга хэмжээнд 196.1 сая, 2022 онд шинээр хэрэгжүүлэх 12 төсөл, арга хэмжээнд 1,376.8 сая төгрөг санхүүжүүлэхээр баталсан.

Замын сангийн харилцах дансанд оны эхэнд 43.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвараар 654.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, туслах үйл ажиллагааны орлогоос 38.9 сая, орон нутгийн орлогоос 1,500.1 сая төгрөгийн санхүүжилт авч 15 батлагдсан төсөл, арга хэмжээнд 1,548.9 сая төгрөгийн зардал гаргаж 33.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хоршоо хөгжүүлэх сан

Сумын Хоршоо хөгжүүлэх сангаас /Сум хөгжүүлэх сан/ олгосон хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн орлогын эргэн төлөлтөөр 2022 онд 20 сум 1,491.7 сая төгрөгийг 5 сум ОНХС-д 375.5 сая төгрөгийг тус тус оруулахаар төлөвлөжээ.

Хүснэгт 11 .Сумын СХС, ОНХС-ийн орлогын төлөвлөгөө /сая төгрөгөөр/

№	Сумын нэр	ОНХС-ийн орлогоор	СХС-ийн орлогоор	№	Сумын нэр	ОНХС-ийн орлогоор	СХС-ийн орлогоор
1	Галуут	39.5	74.0	11	Заг	-	25.5
2	Баян-Овоо	198.0	62.7	12	Баацагаан	-	86.7
3	Эрдэнэцогт	-	17.6	13	Бөмбөгөр	-	41.3
4	Бууцагаан	-	135.0	14	Өлзийт	-	59.5
5	Жинст	-	81.5	15	Хүрээмарал	43.5	100.1
6	Богд	-	34.2	16	Баянбулаг	-	90.0
7	Баянлиг	-	22.3	17	Шинэжинст	75.1	61.0
8	Баянговь	-	49.0	18	Баянцагаан	-	70.0
9	Гурванбулаг	-	61.6	19	Баян-Өндөр	-	63.9
10	Жаргалант	19.4	153.0	20	Баянхонгор	-	202.8
Нийт						375.5	1,491.7

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоолууд

Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангаас 78 зээлдэгчид 2,356.2 сая төгрөгийн зээл олгож өмнөх оны зээлийн үлдэгдлээс 542.4 сая, тайланд онд олгосон зээлээс 350.0 сая төгрөг нийт 892.3 сая төгрөгийн эргэн төлөгдсөн байна.

Аудитын илрүүлэлт:

-Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 1,491.7 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 892.3 сая төгрөг орсон байна. Доорх хүснэгтээс харахад 14 сум зээлийн эргэн төлөлтийг төлөвлөсөн хэмжээнд оруулаагүй байгаа нь зээлийн эргэн төлөлтийг төлөвлөхдөө зээлдэгчийн зээлийн гэрээнд бус, олгох зээлийн хэмжээтэй уялдуулж эх үүсвэрийг төлөвлөж байна. Мөн зээлийн гэрээний хугацаа хэтэрсэн зээлдэгч нарыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн нь зээл төлөгдөх явц удаашралтай байгаатай холбоотой байна.

Иймд Хоршоо хөгжүүлэх /Сум хөгжүүлэх/ сангаас авсан зээлдэгчийн зээлийн гэрээний үүргээ биелүүлж байгаад тавих хяналтыг сайжруулж, эргэн төлөлтийн хуваарийг үндэслэн эх үүсвэрийг бодитой төлөвлөх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

Хүснэгт 12 .Сумын СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Д/д	Сумдын нэр	төлөвлөсөн	төлөгдсөн	төлөгдөөгүй
1	Баянхонгор сумын СХС	202.8	108.4	94.4
2	Бууцагаан сумын СХС	135.0	44.9	90.1
3	Жаргалант сумын СХС	153.0	64.1	88.8
4	Баянбулаг сумын СХС	90.0	33.9	56.1
5	Хүрээмарал сумын СХС	100.1	44.7	55.4
6	Жинст сумын СХС	81.5	30.4	51.1
7	Баян-Овоо сумын СХС	62.7	21.1	41.6
8	Баянговь сумын СХС	49.0	8.8	40.3
9	Галуут сумын СХС	74.0	42.6	31.4
10	Баацагаан сумын СХС	86.7	59.6	27.1
11	Шинэжинст сумын СХС	61.0	39.1	21.9
12	Баян-Өндөр сумын СХС	63.9	44.8	19.1
13	Гурванбулаг сумын СХС	61.6	43.5	18.1
14	Баянцагаан сумын СХС	70.0	53.9	16.1
15	Заг сумын СХС	25.5	26.6	- 1.1
16	Баянлиг сумын СХС	22.3	24.2	- 1.8
17	Богд сумын СХС	34.2	37.0	- 2.9
18	Өлзийт сумын СХС	59.5	72.5	- 13.0

19	Эрдэнэцогт сумын СХС	17.6	33.9	-	16.3
20	Бөмбөгөр сумын СХС	41.3	58.3	-	17.0
	Дүн	1,491.7	892.3		599.4

Хоршоо хөгжүүлэх сан оны эхэнд 2,592.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байснаас тайланд онд зээл, зээлийн хүүгийн орлогоор 1,430.1 сая төгрөгийн орлого оруулахаар батлагдаж гүйцэтгэлээр 998.1 сая төгрөгийн сангийн дансанд төвлөрүүлж, хоршоо хөгжүүлэх сангаас 2,169.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, оны эцэст 1,459.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт13 Сумдын Сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр

Д/д	Сумын нэр	Мөнгөн хөрөнгийн		Д/д	Сумын нэр	Мөнгөн хөрөнгийн	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл			Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Баацагаан сумын СХС	101.3	6.8	11	Бууцагаан сумын СХС	235.3	47.9
2	Баянбулаг сумын СХС	86.0	29.9	12	Галуут сумын СХС	135.2	39.9
3	Баянговь сумын СХС	165.8	6.7	13	Гурванбулаг сумын СХС	59.3	102.7
4	Баянлиг сумын СХС	186.1	210.6	14	Жаргалант сумын СХС	57.5	109.1
5	Баян-Овоо сумын СХС	92.9	326.8	15	Жинст сумын СХС	67.1	0.7
6	Баян-Өндөр сумын СХС	89.0	43.7	16	Заг сумын СХС	85.3	27.2
7	Баянхонгор сумын СХС	729.1	101.4	17	Өлзийт сумын СХС	55.7	40.4
8	Баянцагаан сумын СХС	114.9	59.8	18	Хүрээмарал сумын СХС	63.9	116.4
9	Богд сумын СХС	100.6	26.2	19	Шинэжинст сумын СХС	91.7	38.2
10	Бөмбөгөр сумын СХС	8.0	20.1	20	Эрдэнэцогт сумын СХС	68.1	104.9
Нийт дүн						2,592.8	1,459.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2022 оны нээгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын илрүүлэлт:

- Баянлиг, Гурванбулаг, Хүрээмарал, Эрдэнэцогт сумдын Хоршоо хөгжүүлэх сан нь оны эхэнд 460.9 сая төгрөг үлдэгдэлтэй, тайлант зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөөс 146.3 сая төгрөг орлого төвлөрсөн байхад Хоршоо хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлийг сумын иргэдэд олгож жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажиллаагүй байна.

Иймд дээрх сумдын Засаг дарга нарт Хүнс хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу сумын иргэдэд хөнгөлөлттэй зээлийг журмыг дагуу олгож байх зөвлөмжийг хүргүүлж байна.

Сумдын хоршоо хөгжүүлэх сангийн 2022 оны санхүүгийн тайланд зардлын гүйцэтгэлтэй холбоотой 47.0 сая төгрөгийн алдаа илэрч 47.0 сая төгрөгийг санхүүгийн тайланд залруулж, 286.9 сая төгрөгийн зөрчил илэрч 131.1 сая төгрөгийн төлбөрийн акт, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 213.9 сая төгрөгийн зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

Төсвийн шууд захирагчийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:

- Баянхонгор сумын сум хөгжүүлэх сан 2022 онд олгосон 17 зээлдэгчийн гэрээний эргэн төлөлтийг шалгахад 8 зээлдэгчийн хүүгийн орлого 10.5 сая төгрөгийг төлүүлээгүй, авлагаар тусгаагүй тул төлбөрийн акт тогтоосон.
- Баян-Өндөр сумын зээл авсан иргэн, ААН 18.9 сая, Баацагаан сумын 8 зээлдэгчийн 8.8 сая, Бөмбөгөр сумын 13 иргэний 13.0 сая, Баян-Овоо сумын 10 зээлдэгчийн 58.1 сая төгрөгийн зээлийг төлөөгүй хугацаа хэтрүүлж, гэрээний үүргээ зөрчсөн байхад хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй, барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй тул төлбөрийн акт тогтоосон.
- Баянговь сумын Сум хөгжүүлэх сангаас 2013-2016 онд олгосон 14 иргэний 42.0 сая зээл хугацаа хэтрэлттэй, барагдаагүй тул төлбөрийн акт тогтоосон.
- Хүрээмарал сумын Сум хөгжүүлэх сангаас 2019 онд зээл авсан 3 зээлдэгчийн 14.1 сая төгрөгийн зээлийн гэрээ дуусгавар болсон байхад зээлийг хугацаанд нь төлөөгүй, хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй байгаа тул төлбөрийн акт тогтоосон.

- Баацагаан сумын Хоршоо хөгжүүлэх сангаас 2022 онд 4 зээлдэгчид 153.0 сая төгрөгийн зээл олгосноос Бөөнцагаан хоршоо 0.3 сая төгрөгийн, Буянт таван буурал хоршоо 0.5 сая төгрөгийн зээлийн хүүг санд төвлөрүүлээгүйд төлбөрийн акт тогтоосон;
- Баянлиг сумын сум хөгжүүлэх сангаас СХС-аас 2013-2014 онд олгосон 2 иргэний 24.6 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрснийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсэн боловч 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 2/84 тоот албан бичгээр тухайн үед ажиллаж байсан Засаг дарга А.Бадмаадорж нь иргэний 14.3 сая төгрөгийн зээлийг, 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 120 дугаар албан бичгээр Засаг дарга О.Мөнхбат иргэний 10.3 сая төгрөгийг буцаан татсан бөгөөд дээр зээлийн үлдэгдлийг төлөөгүй байгаа тул зөвлөмж хүргүүлсэн;
- Баян-өндөр сумын сум хөгжүүлэх сан Санхүүгийн тайлангийн зээлийн авлага, хоршоо хөгжүүлэх сангийн программ дахь 2022.12.31-ний өдрөөрх зээлийн үлдэгдлийг тулган шалгахад 8.1 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа тул санхүүгийн тайланд залруулсан.
- Баацагаан сумын Сум хөгжүүлэх сан Санхүүгийн тайлангийн программд СХС-гийн зээлийн авлага 96.3 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 152.8 сая төгрөгийг зээлдэгч бүрээр авлага үүсгэн бүртгээгүй нийт Хувь хүмүүсээс авах, хувийн хэвшлийн ААН-ээс авах авлага гэж бүртгэсэн байгаа тул зөвлөмж хүргүүлсэн.
- Баацагаан сумын Сум хөгжүүлэх сангийн авлагыг санхүүгийн тайланд 1.2 сая төгрөгөөр зөрүүтэй тусгасныг санхүүгийн тайланд залруулсан байна..

БҮЛЭГ 3 АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫГ ЗҮЙ ЗОХИСТОЙ, ҮР АШИГТАЙ БАЙДЛААР ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 54.57-Т ЗААСАН БҮРЭЛДЭХҮҮНЭЭР ГАРГАН, ХЭРЭГЖҮҮЛЖ ХӨТӨЛБӨР АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭХ ҮР ДҮН, ЗОРИЛТОД ТҮВШИНД НИЙЦСЭН БАЙНА.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.12.01-ний өдрийн 6/23 дугаар “Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” тогтоолын 1 дүгээр хавсралтаар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг баталсан. Аймгийн ИТХ-ын 2022.05.25-ний өдрийн 9/24 тогтоолоор 16 хөтөлбөрийг 20,290.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр, урт хугацаат зээлийн эргэн төлөлтөд 316.7 сая, сумдад олгох шилжүүлгийг 14,957.5 сая нийт 35,211.5 сая төгрөгийг баталсан.

Гүйцэтгэлээр 16 хөтөлбөрийг 19,654.7 сая төгрөг зарцуулан хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 14 Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт /сая төг/

Эдийн засгийн ангилал	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл
Нийт төсөв	Хөтөлбөр	Арга хэмжээ	20,290.0	19,654.7
70105	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	1,277.0	1,265.6
		ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаа	180.0	180.0
		ЦАУЗБСК-ийн үйл ажиллагаа	3.0	2.9
70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	3,427.6	3,569.6
		Орон нутгийн засаг захиргааны стратегийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа	2,355.6	2,373.4
71413	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	369.5	367.1
70801	Мал аж ахуйг хөгжүүлэх	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ	633.1	633.1
71101	Авто зам	Замын сан	1,575.9	1,548.4

* Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна

71502	Хот байгуулалт тохижилт	Хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа,Гудамжны гэрэлтүүлэг, цэвэрлэгээ ,Ногоон байгууламжийн үйл ажиллагаа	1,202.0	1,258.2
70426	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	Аймгийн орон нутгийн өмчийн газар	197.7	197.6
72208	Ахмад настны хөгжил хамгаалал	Орон нутгийн ахмад настанд үйлчлэх кабинет төв	187.9	184.8
71411	Хүрээлэн буй орчны бодлого удирдлага	Байгаль орчин аялал жуулчлалын газар	621.1	582.0
71403	Ойжуулалт	Сум дундын ойн анги	115.2	114.8
71902	Нийгмийн халамж Аймгийн халамжийн сан	Баянхонгор аймгийн 768 иргэнд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлнэ	90.4	56.9
		Баянхонгор аймгийн 86 иргэнд амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж үзүүлнэ	59.8	55.2
		Үйл ажиллагааны зардал болон халамжийн санд хяналт шалгалт хийнэ	10.0	2.5
70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	193.8	152.1
71701	Биеийн тамир спорт	Биеийн тамир спорт	835.3	590.5
71702	Соёл урлаг	Соёл урлаг	483.4	468.6
71804	Мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн боловсрол	465.4	465.1
70503	орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	Орон нутгийн хөгжлийн сан, Их засварын арга хэмжээ	6,006.1	5,586.0

Аймгийн ТЕЗ-ийн 2022 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хүрсэн үр дүнгийн талаар

Аймгийн ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгддэг байгууллагууд нь аймгийн Засаг даргатай 2022 оны үр дүнгийн гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтийг тайлагнан дүгнүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсээс аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн 2022 оны биелэлтийг 92.0 хувьтай хэрэгжсэн гэж үнэлсэн байна.

Монгол Улсын Сангийн сайд болон Баянхонгор аймгийн Засаг даргын 2022 онд хамтран ажиллах гэрээг байгуулан гэрээний хэрэгжилтийн 2023.01.13-ны өдөр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн байна.

Гэрээний хэрэгжилтийн тайлангаас товч дурдвал:

Монгол улсын Засгийн газар, Сангийн яамнаас төсөв санхүүгийн талаар баримталж буй бодлого чиглэлийг тухай бүр аймаг сумын хэмжээнд хэрэгжүүлэн 2022 оны төсөв, 2022 оны төсвийн тодотголын төсөл боловсруулахад орсон гол гол өөрчлөлтүүд болон баримтлах зарчмын талаар удирдамжийг боловсруулан хэлтсийн даргын албан тоотоор сумдад хүргүүлж гүйцэтгэлд тухай бүр хяналт тавьж аргагүйгээр хангаж ажиллав.

Нийгмийн даатгалын сан, эрүүл мэндийн даатгалын сангийн төлбөр тооцоог Сангийн сайдын баталсан журмын дагуу төрийн сангийн дансаар дамжуулан 2022 онд нийт 12 тэрбум төгрөгийн гүйлгээг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн төсвийн орлого 2022 оны гүйцэтгэлээр улсын төсөвт 2,797.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 2,972.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 106.3 хувь, орон нутгийн төсөвт 17,210.4 сая төгрөгийн орлого

төвлөрүүлэхээс 21,319.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 123.9 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн байна.

Сангийн сайдын 12 дугаар тушаалын дагуу 2022 онд өр барагдуулах үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 2.5 тэрбум төгрөгийн өртэй 15 аж ахуйн нэгжийг сонгон авч, Татварын ерөнхий хуульд заасан өр хураах шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэн 2.1 тэрбум төгрөгийн өрийг барагдуулж ажилласан.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд батлагдсан төсвийн хүрээнд ажиллаж шаардлагатай тохиолдолд төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийн зохицуулалт хийлгэн өр авлагагүй ажилласан.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авалтыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хууль, журмын дагуу зохион байгуулж, Аймгийн ОНӨГ-ын болон ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын 2022 оны худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайланг цахим системээр нэгтгэн 2022 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/298 тоот албан бичгээр баталгаажуулан хуулийн хугацаанд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.

Аудитын илрүүлэлт:

- *Зарим сумдын Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг сумын ИТХ-аар батлуулж тайлагнаагүй, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтыг хэрэгжүүлээгүй өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна*
Иймд сумдын Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтад нийцүүлэн гаргуулж, цаашид сумдын Засаг дарга нарын санхүүгийн нэгтгээсэн тайланд тавих хяналтыг сайжруулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

БҮЛЭГ 4. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ГАРГАСАН ЗАРИМ ШИЙДВЭРҮҮД НЬ ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛД НИЙЦЭЭГҮЙ, ЗАРИМ БАЙГУУЛЛАГА АЛБАН ТУШААЛТАН ХУУЛИЙГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

Монгол УИХ-аас төр, түүний бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 29-ны өдөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталж мөрдүүлсэн байна.

Засгийн газрын 2022 оны "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 203 дугаар тогтоолоор дараах арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосон байна. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх;
2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх;

- байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.

Баянхонгор аймгийн Засаг даргын харьяа ТШЗ, ТБОНӨХЭ, ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитыг хийж гүйцэтгэх аудитууд, санхүүгийн тайлангийн аудит хийх чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэх аудитын хуулийн этгээд, аудитын хянан удирдах аудитын менежер, баталгаажуулах дарга, тэргүүлэх аудитор нар Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны “Бодлого, чиглэл батлах тухай” А/59 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, МҮЕА-ын 2022 оны “Заавар батлах тухай” А/89 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ийг мөрдлөг болгон ажилласан.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 73.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4.9 сая төгрөгийн зөрчилд 11 төлбөрийн акт тогтоож, 48.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага өгч, 20.2 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 8 зөвлөмж хүргүүлсэн.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгч, орон нутгийн өмчит хуулийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг тогтоож Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.

5 дугаар зүйл. Тэргүүн дэд, дэд, орлогч дарга

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалтын дагуу Баянхонгор аймгийн засаг даргын Б/27 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын байгаль орчин, уул уурхай, нийгмийн бодлогын асуудал хариуцсан орлогч дарга Ж.Мөнхсоёлыг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Мөн хуулийн 5.3, 5.4-т заасан зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд болон тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоог аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд ажиллуулаагүй, шинээр албан тушаал бий болгоогүй байна.

6 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022.12.23-ны өдрийн 95/280 дугаар хамтарсан тушаалаар “Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам”-ыг баталж бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мөрдөж ажиллахыг үүрэг болгосон байна.

Дээрх тушаалд үндэслэн аймгийн Засаг даргын 2023.02.17-ны өдрийн “Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжилтийг хангах тухай” А/103 дугаар захирамжаар “Орон нутгийн өмчит байгууллага, хуулийн этгээд тээврийн хэрэгслийг ашиглаж, эзэмших

журам”, “Албан тушаалын, албан ажлын суудлын автомашины тоо, төрөл, автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг баталж журмаар зөвшөөрөгдөөгүй нийт 78 тээврийн хэрэгслийг татан төвлөрүүлэхийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт үүрэг болгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын 2 дахь “Энэ тогтоолын 1-д заасны дагуу татан төвлөрүүлсэн төрийн өмчид бүртгэлтэй суудлын автомашиныг “Засгийн газрын авто бааз” УТҮГ-т, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашиныг тухайн аймаг, нийслэлийн харьяа авто тээврийн байгууллагад шилжүүлж, төрийн болон орон нутгийн байгууллагын нийтлэг үйлчилгээний хүрээнд дуудлагын автомашины зориулалтаар ашиглуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тус захирамжийн дагуу төсөвт байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглаж байсан 44 автомашиныг аймгийн Орон нутгийн өмчийн газарт татан төвлөрүүлж аймгийн Засаг даргын 2023.03.20-ны өдрийн А/147 дугаар захирамжаар 20 тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, 6 автомашиныг акталж, 10 автомашиныг автомашин дутагдалтай төсөвт байгууллагуудад балансаас баланст шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Харин 28 байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 34 тээврийн хэрэгслийг Орон нутгийн өмчийн газарт 2023.03.25-ны өдрийн байдлаар ирүүлээгүй байна.

Иймд аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар тус автомашинуудыг татан төвлөрүүлж Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн шууд захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 3 төсвийн байгууллага Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийг зөрчиж 17.1 сая төгрөг зарцуулсан зөрчил илэрсэнд дараах арга хэмжээг авч ажилласан.

Хүснэгт 15. Тээврийн хэрэгсэлтэй холбоотой зөрчлийн нэгтгэл /сая төгрөгөөр/

Хуулийн заалт	Зөвлөмж		Төлбөрийн акт		Нийт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
6 дугаар зүйлийн 6.3.	2	16.9	1	0.2	3	17.1
Дүн	2	16.9	1	0.2	3	17.1

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

7 дугаар зүйл. Албан тасалгаа

Тус онд орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд захиргааны зориулалттай барилга, байгууламж барихад хөрөнгө зарцуулаагүй байна.

Харин Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нэг албан хаагчид 16.8м2 буюу 8.8 м2 илүү буюу Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”-ийг зөрчсөн зөрчил илэрсэнд цаашид

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, байрны ашиглалтыг сайжруулах арга хэмжээг авч, зөрчлийг арилгах албан шаардлага өгсөн.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн шууд захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн 11 байгууллагын даргын албан өрөөний талбайн хэмжээ нь дээрх Засгийн газрын тогтоолд заасан хэмжээнээс илүү байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална” гэсэн байгаа ч дээрх 2002 оны тогтоолыг шинэчлэн батлаагүй тул дээрх илүү талбайн хэмжээг зөрчлөөр тооцох боломжгүй байгаа болно.

8 дугаар зүйл. Дүрэмт хувцас

Орон нутгийн төсөвт байгууллагын албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдаж авах зардал төлөвлөж зарцуулсан зөрчил илрээгүй болно.

9 дүгээр зүйл. Албан томилолт

Баянхонгор аймагт агаарын тээврийн нислэг байхгүй бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь заалтыг зөрчиж төсвөөс хөрөнгө зарцуулсан зөрчил илрээгүй болно.

10 дугаар зүйл. Цалин хөлс, нэмэгдэл

Баянхонгор аймгийн Засаг даргын харьяа орон нутгийн өмчит 8 аж ахуйн нэгж байгаа тус аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэх удирдлагын цалин хөлсийг аймгийн ИТХ-аас тогтоогоогүй ба 5 аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагын цалинг Төлөөлөн удирдах зөвлөл, 3 аж ахуйн нэгжийн гүйцэтгэх удирдлагын цалинг аймгийн Засаг даргын захирамжаар тогтоосон байна.

Хүснэгт 16. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын цалин тогтоосон шийдвэр

№	Хуулийн заалт	Гүйцэтгэх удирдлагын цалин, хөлсийг тогтоосон субъект, шийдвэр
1	“Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
2	Чандмань Баянхонгор ХК	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
3	“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
4	“Цэвэр хот” ОНӨААТҮГ	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол
5	“Баянхонгор аймгийн Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ	Аймгийн Засаг даргын захирамж
6	“Ингэн эрдэнэ” ОНӨААТҮГ	Аймгийн Засаг даргын захирамж
7	“Жаргалтай амьдрал, сэтгэц, нийгмийн сэргээн засах эмчилгээний төв” ОНӨААТҮГ	Аймгийн Засаг даргын захирамж
8	Баян өсөх агро ОНӨААТҮГ	Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын баримтаас

Мөн орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг аймгийн ИТХ-аас тогтоож мөрдүүлээгүй байна.

Энэ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг зөрчиж байгаа тул аймгийн Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Орон нутгийн өмчит хуулийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн..

11 дүгээр зүйлийн. Нэг удаагийн мөнгөн тэтгэмж

Тус онд төрийн албан хаагчдад тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг хуульд заасан үндэслэл хэмжээгээр төлөвлөж олгож байгаа бөгөөд давхардуулан олгоогүй байна.

12 дугаар зүйл. Бусад хангамж

Бусад хангамжийн зардал болох гар утасны зардал, ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсвэл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал, хэвлэлийн захиалгын төлбөр зэрэг зардлуудыг төсвөөс төлөхөөр төсвийн төсөлд тусгаж төлөвлөөгүй байна.

Гэсэн хэдий ч Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн шууд захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 2 төсвийн байгууллага Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийг зөрчиж 0.7 сая төгрөг батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.

Хүснэгт 17. Бусад хангамжтай холбоотой зөрчлийн нэгтгэл

Хуулийн заалт	Албан шаардлага		Төлбөрийн акт		Нийт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
12 дугаар зүйлийн 12.1.1.		-	2	0.7	2	0.7
Дүн		-	2	0.7	2	0.7

/сая төгрөгөөр/

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

13 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

Аймгийн 2022 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгон батлагдсан төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 21 нэр төрлийн 80.5 тэрбум, гадаадын төслийн санхүүжилтээр 6 нэр төрлийн 0.5 тэрбум төгрөгийн, бусад төсвийн санхүүжилтээр 3 нэр төрлийн 0.2 тэрбум төгрөгийн орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 40 нэр төрлийн 6.9 тэрбум төгрөгийн, нийт 70 нэр төрлийн 88.2 тэрбум төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ний хооронд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 30 нэр төрлийн 81.2 тэрбум төгрөгийн, орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалттай 6.9 тэрбум төгрөгийн 40 төсөл арга хэмжээ, нийт 70 нэр төрлийн 88.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгосон төлөвлөгөөний тендер зохион байгуулалтын үйл ажиллагаа 100%-ийн биелэлттэй гарсан байна.

Улсын болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээр ашиглалтын норм дуусаагүй ижил төрлийн барилга байгууламж барих төслийн санал гаргаагүй.

Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4-т заасан хориглох хөрөнгө оруулалтыг тусгаагүй байна.

14 дугаар зүйл Цахим худалдан авалт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд нээлттэй тендер шалгаруулалтын журмаар худалдан авч буй бараа, ажил, үйлчилгээний урилгыг ерөнхий гэрээгээр Зууны мэдээ сонинд нийтлүүлсэн байна.

Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газрууд 2018 оноос одоог хүртэл ерөнхий гэрээгээр эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авч байгаа бөгөөд энэ оны хувьд ерөнхий гэрээний жагсаалтад орсон эм, эмнэлгийн хэрэгслээс 59 нэр төрлийн эм, 4 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл худалдан авч байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 72 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн tender.gov.mn цахим системээр 100% зохион байгуулж тендерийн урилга, үр дүнг цахим системд тухай бүр оруулан ажиллаж байна.

Мөн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/452 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн боловсролын салбарын байгууллагуудад нөхөн хангалтын зардалд нийт 963,585.0 мянган төгрөгийн төсөв хуваарилж цахим дэлгүүрээс тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Харин Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас төсвийн шууд захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Баян-Овоо сумын ЗДТГ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг зөрчиж цахимаар худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй зөрчил илэрсэнд албан шаардлага өгсөн.

15 дугаар зүйл.Хэмнэлтийн бусад арга хэмжээ

